



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СЭА-2026/129/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.УЯНГА ТАНАА**

2026.02.25 № СЭА-2026/129/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 40,477.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>243,403,423.39</b>	<b>68,976,406.48</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө		243,403,423.39	68,976,406.48
31211	Төрийн сангийн харилцах		243,403,423.39	68,976,406.48
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>1,352,895.32</b>	<b>1,367,511.32</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,352,895.32	1,367,511.32
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>192,129,281.06</b>	<b>174,489,826.43</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>		<b>88,856,193.08</b>	<b>86,632,520.08</b>
35110	Тусгай зориулалтай материал		88,824,193.08	86,632,520.08
35130	Эм боох материал		32,000.00	-
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>103,273,087.98</b>	<b>87,857,306.35</b>
3541	Бичиг хэрэг		-	330,000.00
3542	Аж ахуйн материал		36,447,665.41	29,892,143.41
3545	Барилгын засварын материал		2,981,000.00	1,200,000.00
3546	Хүнсний материал		1,631,350.00	15,320.37
3547	Бусад хангамжийн материал		62,213,072.57	56,419,842.57
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>436,885,599.77</b>	<b>244,833,744.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>3,407,823,741.20</b>	<b>3,894,875,805.84</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>3,185,985,361.76</b>	<b>3,674,212,626.60</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		3,127,776,908.46	3,475,935,739.46
39202	Хуримтлагдсан элэгдэл		-274,702,902.49	- 328,065,516.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		356,612,194.00	411,299,100.90
39206	Хуримтлагдсан элэгдэл		-187,340,517.75	-141,039,737.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		251,306,734.50	263,378,966.50
39208	Хуримтлагдсан элэгдэл		-158,535,989.84	-77,026,444.14
39214	Бусад үндсэн хөрөнгө		26,150,790.00	26,150,790.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-10,913,876.96	-13,252,564.88
39217	Ном		55,632,021.84	56,832,292.72
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>221,838,379.44</b>	<b>220,663,179.24</b>
39301	Программ хангамж		7,290,000.00	7,290,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-4,249,000.56	-5,424,200.76
39303	Бусад биет бус хөрөнгө		218,797,380.00	218,797,380.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,407,823,741.20</b>	<b>3,894,875,805.84</b>
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>3,844,709,340.97</b>	<b>4,139,709,550.07</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9</b>	<b>412,500.00</b>	<b>-</b>
413	Өглөг		412,500.00	-
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		412,500.00	-
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>412,500.00</b>	<b>-</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>3,844,296,840.97</b>	<b>4,139,709,550.07</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		712,076,817.42	712,076,817.42
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		-	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		712,076,817.42	712,076,817.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>3,132,220,023.55</b>	<b>3,427,632,732.65</b>
5121	Өмнөх үеийн үр дүн		3,132,220,023.55	3,132,220,023.55
5122	Тайлант үеийн үр дүн		-	295,412,709.10

513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		-	-
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,844,296,840.97</b>	<b>4,139,709,550.07</b>
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>3,844,709,340.97</b>	<b>4,139,709,550.07</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,081,858,580.71</b>	<b>2,209,288,342.95</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,889,907,100.00</b>	<b>1,997,607,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,889,907,100.00	1,997,607,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>191,951,480.71</b>	<b>211,681,342.95</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,951,480.71	211,681,342.95
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>163,382,864.70</b>	<b>592,095,761.98</b>
120	Нийтлэг татварын бус орлого	163,382,864.70	592,095,761.98
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>24,366,900.00</b>	<b>9,883,780.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	4,578,780.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,276,900.00	5,305,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	120,927,859.40	566,506,335.18
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,088,105.30	15,705,646.80
122	Тусламжийн орлого	-	-
1221	Хандив тусламж /дотоод/	-	-
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	-
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	-
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,245,241,445.41</b>	<b>2,801,384,104.93</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,102,151,484.54	2,505,971,395.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,018,656,504.54	2,379,218,156.20
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,405,903,645.99</b>	<b>1,710,104,020.69</b>
210101	Үндсэн цалин	948,824,291.20	1,048,119,144.47
210102	Нэмэгдэл	399,243,854.79	539,084,678.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	49,174,300.10
210104	Урамшуулал	57,835,500.00	73,725,897.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>173,819,769.05</b>	<b>211,044,347.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	119,365,706.88	145,037,600.32
210202	Тэтгэмжийн даатгал	15,856,207.54	17,068,760.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,962,131.73	8,530,725.59
210204	Ажилгүйдлийн даатгал	6,895,648.72	8,096,395.61
210205	Эрүүл мэндийн даатгал	24,740,074.18	32,310,865.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>172,951,480.71</b>	<b>191,681,343.65</b>
210301	Гэрэл, цахилгаан	35,186,973.96	28,632,157.99

210302	Түлш, халаалт	119,272,032.75	146,041,461.66
210303	Цэвэр, бохир ус	18,492,474.00	17,007,724.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>256,000.00</b>
210502	Хоол, хүнс	-	256,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<b>19,000,000.00</b>	<b>19,999,999.30</b>
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,999,999.30
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,404,863.44</b>	<b>30,402,793.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,368,900.00	3,021,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,035,963.44	27,380,993.08
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>215,576,745.35</b>	<b>215,729,652.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,293,016.95	75,556,021.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,308,050.00	12,169,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,975,678.40	128,004,270.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,494,980.00</b>	<b>126,753,239.63</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>83,494,980.00</b>	<b>126,753,239.63</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,853,780.00	100,443,219.63
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,641,200.00	26,310,020.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,102,151,484.54</b>	<b>2,505,971,395.83</b>
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	143,089,960.87	295,412,709.10
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>143,089,960.87</b>	<b>295,412,709.10</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,106,225,480.71</b>	<b>2,219,172,122.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,366,900.00</b>	<b>9,883,780.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	24,366,900.00	9,883,780.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,366,900.00	9,883,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,461,900.00	4,578,780.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,905,000.00	5,305,000.00
122	Тусламжийн орлого	-	-
1221	Хандив тусламж /дотоод/	-	-
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	-
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,081,858,580.71</b>	<b>2,209,288,342.95</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	<b>1,889,907,100.00</b>	<b>1,997,607,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,889,907,100.00	1,997,607,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<b>191,951,480.71</b>	<b>211,681,342.95</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,951,480.71	211,681,342.95
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,975,160,501.37</b>	<b>2,345,049,139.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,975,160,501.37</b>	<b>2,345,049,139.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,891,452,915.37</b>	<b>2,219,911,929.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,404,689,725.02</b>	<b>1,710,465,407.09</b>
210101	Үндсэн цалин	877,538,612.48	1,048,119,144.47
210102	Нэмэгдэл	469,315,612.54	539,446,065.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	49,174,300.10
210104	Урамшуулал	57,835,500.00	73,725,897.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>174,621,190.02</b>	<b>211,110,076.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	120,213,115.11	145,103,329.92
210202	Тэтгэмжийн даатгал	14,098,818.34	17,068,760.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,051,358.97	8,530,725.59
210204	Ажилгүйдлийн даатгал	6,649,239.56	8,096,395.61
210205	Эрүүл мэндийн даатгал	26,608,658.04	32,310,865.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>172,951,480.71</b>	<b>191,681,343.65</b>
210301	Гэрэл, цахилгаан	35,186,973.96	28,632,157.99
210302	Түлш, халаалт	119,272,032.75	146,041,461.66
210303	Цэвэр, бохир ус	18,492,474.00	17,007,724.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>256,000.00</b>
210502	Хоол, хүнс	-	256,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,000,000.00</b>	<b>19,999,999.30</b>
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,999,999.30
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,404,863.44</b>	<b>37,416,793.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,368,900.00	3,021,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,035,963.44	34,394,993.08
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>88,785,656.18</b>	<b>48,982,310.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,246,556.18	36,390,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,539,100.00	12,591,510.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,707,586.00</b>	<b>125,137,210.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,707,586.00	125,137,210.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,066,386.00	98,827,190.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,641,200.00	26,310,020.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>131,064,979.34</b>	<b>-125,877,016.91</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,725,600.00</b>	<b>48,550,000.00</b>
22	Дотоод эх үүсвэрээр	29,725,600.00	48,550,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	48,550,000.00
223001	Бусад хөрөнгө	29,725,600.00	
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-29,725,600.00</b>	<b>-48,550,000.00</b>

VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>101,339,379.34</b>	<b>(174,427,016.91)</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	142,064,044.05	243,403,423.39
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	243,403,423.39	68,976,406.48

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>712,076,817.42</b>	-	<b>3,132,220,023.55</b>	<b>3,844,296,840.97</b>
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	712,076,817.42	-	3,132,220,023.55	3,844,296,840.97
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			295,412,709.10	295,412,709.10
19	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>712,076,817.42</b>	<b>0.00</b>	<b>3,427,632,732.65</b>	<b>4,139,709,550.07</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,516,343,100.00</b>	<b>2,209,288,342.95</b>	<b>307,054,757.05</b>	<b>87.8</b>
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,202,885,200.00</b>	<b>1,997,607,000.00</b>	<b>205,278,200.00</b>	<b>90.7</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,202,885,200.00	1,997,607,000.00	205,278,200.00	90.7
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	40,398,600.00			
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>313,457,900.00</b>	<b>211,681,342.95</b>	<b>101,776,557.05</b>	<b>67.5</b>
132001	Орон нутгийн төсвөөс	313,457,900.00	211,681,342.95	101,776,557.05	67.5
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,626,700.00</b>	<b>9,883,780.00</b>	<b>742,920.00</b>	<b>93.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,616,700.00	4,578,780.00	37,920.00	99.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,010,000.00	5,305,000.00	705,000.00	88.3
122	<b>Тусламжийн орлого</b>				
122005	Төсвөөс санхүүжих				

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,567,368,400.00</b>	<b>2,219,172,122.95</b>	<b>307,797,677.05</b>	<b>87.8</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>2,567,368,400.00</b>	<b>2,393,599,139.86</b>	<b>173,769,260.14</b>	<b>93.2</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,435,117,400.00	2,268,461,929.86	166,655,470.14	93.2
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,753,915,000.00</b>	<b>1,710,465,407.09</b>	<b>43,449,592.91</b>	<b>97.5</b>
210101	Үндсэн цалин	1,157,912,900.00	1,048,119,144.47	109,793,755.53	90.5
210102	Нэмэгдэл	541,908,800.00	539,446,065.39	2,462,734.61	99.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт		49,174,300.10	(49,174,300.10)	-
210104	Урамшуулал	54,093,300.00	73,725,897.13	(19,632,597.13)	136.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>219,239,200.00</b>	<b>211,110,076.74</b>	<b>8,129,123.26</b>	<b>96.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	149,082,700.00	145,103,329.92	3,979,370.08	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	17,539,200.00	17,068,760.12	470,439.88	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,769,500.00	8,530,725.59	238,774.41	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	8,769,500.00	8,096,395.61	673,104.39	92.3
210205	Эрүүл мэндийн даатгал	35,078,300.00	32,310,865.50	2,767,434.50	92.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>293,457,900.00</b>	<b>191,681,343.65</b>	<b>101,776,556.35</b>	<b>65.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	60,750,000.00	28,632,157.99	32,117,842.01	47.1
210302	Түлш, халаалт	210,707,900.00	146,041,461.66	64,666,438.34	69.3
210303	Цэвэр, бохир ус	22,000,000.00	17,007,724.00	4,992,276.00	77.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>256,000.00</b>	<b>256,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210502	Хоол, хүнс	256,000.00	256,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,000,000.00</b>	<b>19,999,999.30</b>	<b>0.70</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,999,999.30	0.70	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,035,000.00</b>	<b>37,416,793.08</b>	<b>2,618,206.92</b>	<b>93.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,021,800.00	3,021,800.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,013,200.00	34,394,993.08	2,618,206.92	92.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>108,214,300.00</b>	<b>97,532,310.00</b>	<b>10,681,990.00</b>	<b>90.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,039,800.00	84,940,800.00	10,099,000.00	89.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,174,500.00	12,591,510.00	582,990.00	95.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>132,251,000.00</b>	<b>125,137,210.00</b>	<b>7,113,790.00</b>	<b>94.6</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,251,000.00	125,137,210.00	7,113,790.00	94.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	105,940,900.00	98,827,190.00	7,113,710.00	93.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,310,100.00	26,310,020.00	80.00	100.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>2,567,368,400.00</b>	<b>2,393,599,139.86</b>	<b>173,769,260.14</b>	<b>93.2</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		243,403,423.39	(243,403,423.39)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,976,406.48	(68,976,406.48)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	56	56		100.0

6	Удирдах ажилтан	1	1	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	38	38	100.0
8	Үйлчлэх ажилтан	17	17	100.0

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 6,234.1 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлан онд худалдан авсан ухаалаг самбар, ухаалаг дэлгэц, иж бүрэн компьютер, гурил зуурагч зэргийг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 6,234.1 мянган төгрөгийн сөрөг утгаар илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,767.5 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс 400.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,367.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 400.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас багш нарын баярт зориулсан спортын тэмцээний бооцоонд 400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага ... дараах зүйлийг хориглоно*”, 15.1.8 дахь “*байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.1 Илрүүлэлт:** Он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй 1,367.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйцэтгэх удирдлага хүлээнэ. 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Дээрх авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлан онд худалдан авсан ухаалаг самбар, ухаалаг дэлгэц, иж бүрэн компьютер, гурил зуурагч зэргийг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд сөрөг утгаар илэрхийлсэн байна.	1	6,234.1			1	6,234.1	1	6,234.1				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6,234.1</b>			<b>1</b>	<b>6,234.1</b>	<b>1</b>	<b>6,234.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Уралдаан тэмцээн ивээн тэтгэсэн	1	400.0			1	400.0						

Он дамжсан авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй	1	1,367.5					1	1,367.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,767.5</b>			<b>1</b>	<b>400.0</b>	<b>1</b>	<b>1,367.5</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			